



БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
Д.ЧИНХҮСЭЛ ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024. 07. 31 № 236

танай _____ -ны № _____ -т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн Даваагийн Чинхүсэлийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого,

0702 00842

УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Д.Чинхүсэлийн Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Д.Чинхүсэлийн мөрийн хөтөлбөр (.....¹..... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Дарив сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Говь-Алтай аймгийн Дарив сумын ИТХ-ын сонгуульд бие даан нэр дэвшигч
Даваагийн Чинхүсэлийн 2024-2028 оны мөрийн хөтөлбөр

Зорилт: Дарив сумын үйлдвэр багийн иргэдийн тав тухтай, цэвэр эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх

1. Сумын төвийн хогийн цэгийг сайжруулж, хогийг ангилан ялгаж эргүүлэн ашигладаг болгоно.
2. Төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, багийн иргэдийг ажлын байраар хангаж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.
3. Нийтийн эзэмшлийн болон сумын төвийн айл өрхүүдийн хашаа хорооны өнгө үзэмжийг сайжруулна.
4. Цагаан булаг хорооллын айл өрхийн тогны хүчин чадлыг сайжруулж холбогдох байгууллагатай хамтарч ажиллана.
5. Сургуулийн спорт заалны дутуу барилгыг гүйцээх талаар дээд байгууллагуудад уламжилж шийдвэрлүүлнэ.
6. Сумын төвийн айл өрх, зарим албан газруудыг төвийн нэгдсэн халаалтанд хамруулах ажлыг холбогдох байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран зохион байгуулна.
7. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
8. Сумын төвийн ундны усны худгийн ариутгал халдваргүйжүүлэлтэнд тавьж хүнсний аюулгүй байдалд анхаарч ажиллана.
9. Төрийн болон төрийн бус байгууллагуудын санал санаачлагыг дэмжиж, үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
10. Сумын төвийн айл өрхүүдийг соруулдаг, боловсон нойлтой болгоно.
11. Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгийг зөв зохистой зарцуулж хяналт тавьж ажиллах
12. Сумын ахуйн үйлчилгээний хөгжлийн ордонг бариулах талаар холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.
13. Сумын айл өрхүүдийг угийн бичиг хөтлөх, ургийн баяр хийх үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН:
БИЕ ДААГЧ Д.ЧИНХҮСЭЛ